

2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ (2025 оны эхний хагас жилийн байдлаар)

Жич: Тайланг 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлэх

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Санхүүжилт сая төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Биелэлт	Үр дүн
НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
САЛБАРЫН ҮР ДҮН: 1 БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.											
1.1 Боловсролын сургалтын байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1.1.1 Стандартын шаардлагад нийцсэн сургалтын орчныг сайжруулна.	АХ-2.1.12. МУХТЖҮЧ-2.1.8, МУЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-2.2.1.7 ДАХТЖҮЧ-2.3.1	1.1.1.1 Сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламжийг нэмэгдүүлэх	Цэцэрлэгийн барилгын ажил /тухайн онд үргэлжлэх/	Тоо	2	1	1215.8	Улсын төсөв	Хэрлэн сумын 11-р багт баригдаж буй цэцэрлэгийн барилгын ажлыг “Талын сүлд” ХХК гэрээний дагуу 90.0 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөний дагуу хэвийн гүйцэтгэж байна. Боловсролын газраас уг барилгыг 2025 оны 8 дугаар сард ашиглалтанд хүлээлгэн өгөх хүсэлтийг гүйцэтгэгч компанид хүргүүлэн, хамтран ажиллаж байна. Цэцэрлэгийн барилга 150 ор, /Дорнод, Хэрлэн сум 4 баг/ - Ажлын гүйцэтгэл 100%, Улсын комисс 2024 оны 12-р сарын 02-нд үүрэг даалгаварын биелэлтээр хүлээж авсан.	1 цэцэрлэг ашиглалтад орсон байна.
			Шинээр ашиглалтад орсон цэцэрлэгийн барилга	Тоо	-	1					
						Сургуулийн барилгын ажил /тухайн онд үргэлжлэх/	Тоо	Тоо	5	4	7019.1

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Санхүүжилт сая төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Биелэлт	Үр дүн
				Шинээр ашиглалтад орсон сургуулийн барилга	Тоо	-	1	1285.5	Улсын төсөв	Улсын төсвөөр баригдсан Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/ - Ажлын гүйцэтгэл 100%, Улсын комисс 2024 оны 12-р сарын 03-нд үүрэг даалгаварын биелэлтээр хүлээж авсан.	Ашиглалтад орсон.
				Шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилга	Тоо	-	1	1903.0	Улсын төсөв	2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 дотуур байрны барилга ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд: - “Өндөр баганат” ХХК-ний барьж гүйцэтгэж буй Цагаан-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. 2024 онд ашиглалтад орох ёстой байсан барилгын ажил удаашралтай явагдаж байна. - Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 160 хүүхдийн ортой дотуур байрны барилгыг “Дорнын оч” ХХК батлагдсан төлөвлөгөөний дагуу хэвийн гүйцэтгэж, 80 хувийн гүйцэтгэлтэй байна.	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хэвийн гүйцэтгэж байна.
				Шинээр баригдаж эхлэх спорт заал	Тоо	-	1	1373.4	Орон нутгийн төсөв	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга барих (Баянтүмэн сумтай хамтран) – Тод сүндрлэ ХХК гэрээ байгуулсан. Барилгын улаан шугам тавих ажил хийгдсэн ба суурийн ажл хийгдэж байна.	Барилгын ажлын гүйцэтгэл 5%
				Түрээсээр ашиглагдах цэцэрлэг	Тоо	1	1	150.0	Орон нутгийн төсөв	Аймгийн Хэрлэн сумын 7 дугаар багт байрлах хувийн хэвшлийн “Сэргэлэн багачууд” цэцэрлэгийн барилгыг ашиглах түрээсийн гэрээ байгуулан, Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн салбар бүлгээр нэмж 5 бүлгийн 152 хүүхдийг хамруулан, 2025 оны түрээсийн төлбөрт 63.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт батлан санхүүжүүлж байна.	Гэрээний дагуу төлбөр төлөгдөөд хэвийн явж байна.
		АХ-2.1.12. МУХТЖҮЧ-2.1.8, МУЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-2.2.1.7, ДАХТЖҮЧ-2.3.1	1.1.1.2 Сургуулийн өмнөх боловсролын болон Ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламжийг засварлах, өргөтгөх	Засварласан барилга, байгууламж	Тоо	12	18	3,459.6	Орон нутгийн төсөв	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 14 төсөл, арга хэмжээ батлагдаж, өнөөдрийн байдлаар 2 арга хэмжээ гэрээний дагуу ажлаа гүйцэтгэж комисс ажиллуулах хүсэлтээ өгөөд байна. 12 ажил гэрээ байгуулан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа амрахаар ажил гүйцэтгэхэд бэлэн болоод байна.	Гэрээ, ажлын графикийн дагуу ажлаа хугацаандаа хийж гүйцэтгэнэ.
			1.1.1.3 Сургуулийн өмнөх боловсролын болон Ерөнхий боловсролын	Багшийн компьютер	Тоо	152	305	145.4	Орон нутгийн төсөв	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг компьютержуулах /Сумдтай хамтран/ - Ажлын гүйцэтгэл 100%. Санхүүжилтыг 2024, 2025 онд шилжүүлэн олгохоор гэрээ байгуулсан. 2024 оны санхүүжилт 100% хийгдсэн. 2025 оны санхүүжилт гэрээний хийгдэж байна.	Сумдын цэцэрлэг, сургуулийн 305 багш зөөврийн компьютертэй болсон.

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл хэмжээ арга	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Санхүүжилт сая төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Биелэлт	Үр дүн
			сургуулийн техник хэрэгслийг нэмэгдүүлэх	Байгалийн шинжлэх ухааны туршилтын багаж хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлсэн сургууль	Тоо	-	2	28.0	Орон нутгийн төсөв	Байгалийн ухааны хичээлийн туршилтын багаж тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах зорилгын хүрээнд Хэрлэн сумын 12-р сургуульд 18 сая төгрөгийн физикийн иж бүрэн лабораторын тоног төхөөрөмжийг “Байгаль шинжлэл-2025” төслийн хүрээнд шийдвэрлэсэн. Суралцагчдын судлан шинжлэх чадварыг дэмжих чиглэлийн хүрээнд Байгаль шинжлэл-2025” төслийг хэрэгжүүлсэн. Ерөнхий боловсролын 18 сургуулийн 4, 5 дугаар ангийн Хүн байгаль хичээлээр-119, 6-11 дүгээр ангийн физикийн хичээлээр 384, химийн хичээлээр 549, газарзүйн хичээлээр 189, биологийн хичээлээр 100, нийт 1341 туршилтат контентийг 1360 хүүхэд бүтээж, “Дорнод Эврика” фэйж хуудсанд байршуулж, 36707 хүн контентыг үзэж сонирхсон. Аянд оролцсон суралцагчдын тоог 2024 онтой харьцуулахад 831-ээр нэмэгдсэн байна. Туршилтат олимпиад. Байгалийн ухааны 4 хичээлийн 70 багийн 140 суралцагч хамрагдаж туршилтат бодлого бодож оюун ухааны сорилоо. “Дорнод эврика-2025” тайлант өдөрлөгт 4 төрлөөр 23 сургуулийн 4 судлагдахууны 55 мэргэжлийн багш, химийн хичээлийн 15, физикийн хичээлийн 18, Биологийн хичээлийн 18, газарзүйн хичээлийн 8 дугуйлангийн 590 сурагч оролцож шинжлэн ухаан танин мэдэхүйн 92 бүтээлийг танилцуулж, түгээн дэлгэрүүлэлт хийсэн.	Суралцагчдын шинжлэн судлах арга барил буюу амжилт чанарын үзүүлэлт 2024 онд дундаж-4.1, 2025 онд дундаж-10.8 болж өссөн. 2024 онд 35 дугуйлангийн 50 бүтээл, 2025 онд 59 дугуйлангийн 92 бүтээл танилцуулсан
	1.1.2 Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг сайжруулна.	АХ-1.2.4, 3.5.12, МУЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-2.2.2.5, ДАХТЖҮЧ-3.1.5	1.1.2.1 Элсэлтийн шалгалтын эрчимжүүлсэн сургалт зохион байгуулах, амжилт үзүүлсэн багш, сурагчдыг урамшуулах	Амжилт гаргасан суралцагч, массаар амжилттай сургасан багш	Тоо	33	36	50.2	Орон нутгийн төсөв	Суралцагчид өөрийн сонгосон мэргэжил, чиглэлийн дагуу гүнзгийрүүлэн судлах, суралцагчдын ялгаатай байдлыг арилгах, тэгш хамран сургахад мэргэжлийн өндөр түвшний ур чадвартай багш нараас дэмжлэг авах бололцоог бүрдүүлэн, агуулгын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжиж, дээд амжилт үзүүлсэн 10 сурагч, 26 багшийн хөдөлмөрийг бодитоор үнэлж, урамшуулахаар ажиллаж байна.	Одоогоор 5 суралцагч 7 хичээлээр 800 оноог дүйцүүлээд байна.
		АХ- 2.1.40 МУХТЖҮЧ-2.1.7, МУЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-2.2.3.2, ДАХТЖҮЧ-3.1.3	1.1.2.2 Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Нийгмийн баталгаа сайжирсан багш	Тоо	30	62	670.0	Орон нутгийн төсөв	Багшийн хөгжлийг дэмжих Эрдэм төслийн хүрээнд цэцэрлэгийн багш, бага ангийн багш нарын хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, боловсролын олон талт үйл ажиллагаанд хамруулж мэргэжил, ур чадварыг дээшлүүлэн ажлын үр дүнгээр нь орон сууцны урьдчилгаа, төлбөрийн дэмжлэг үзүүлэх болзолт уралдаан 2025 оны оны 2-6 дугаар сарын хугацаанд 3 үе шаттай амжилттай зохион байгуулагдлаа.	Сургуулийн Өмнөх Боловсролын 2 багш, 1 туслах багш, бага ангийн 28 багш нийт 31 багш энэхүү 20 сая төгрөгийн дэмжлэгийг

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Үндсэн ажиллагаа, төсөл хэмжээ арга	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Санхүүжилт сая төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Биелэлт	Үр дүн
										Төслийн хугацаанд багш нар багшлахуйн ур чадвартаа олон сайн туршлагыг хуримтлуулан, бүтээлч олон талт үйл ажиллагааг санаачлан хийж, тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүлэн ажилласан.	авлаа.
				Мэргэжлийн зэрэг нэмэгдсэн багш	Тоо	667	712				2025 онд Тэргүүлэх багшийн тоо 51-ээр нэмэгдсэн.
САЛБАРЫН ҮР ДҮН: 3 ЗОРИЛТОД БҮЛГИЙН ХҮН АМЫГ ДЭМЖИНЭ.											
3.1 Хүүхдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлнэ.	3.1.1. Хүүхдийн авьяас, ур чадварыг сайжруулна.	МУЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-2.1.4.3, АХ-1.2.4, 3.5.12 ДАХТЖҮЧ-3.1.5	3.1.1.1 "Хүн болох багаасаа" сургалтын төслийг үргэлжлүүлэх	Хамрагдсан хүүхэд	Тоо	7465	7465	1892.0	Орон нутгийн төсөв	Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр орон нутгийн "Хүн болох багаасаа" хүүхдийн гадаад хэлний сургалтын төслийн 17 хуулийн этгээдтэй 05 дугаар сарын 01-ны өдрөөс гэрээ байгуулан орос, хятад, англи, япон, солонгос хэлний 34-56 цагийн сургалтад аймгийн 25 сургуулийн 8-10 насны 2373 суралцагч хамрагдан гадаад хэлний мэдлэгээ нэмэгдүүлсэн. Аймгийн 25 сургууль, орон нутгийн "Норвуужай", "Жигүүрт" "Goo English" сургалтын төвийн гадаад хэлний 68 багш, хувь хүний хөгжлийн 8 багш сургалтын төсөлд ажиллаж байна.	Аймгийн 25 сургуулийн 8-10 насны 2373 суралцагч хамрагдаж байна.
				Ахицын үнэлгээний өсөлт	Хувь	-	20				Ахицын үнэлгээ жилийн эцэст хийгдэнэ.